

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

“АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ, ХЯНАЛТ ТАВИХ
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН
2024 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ


2024.03.01

Дархан-Уул аймаг

Архидалтаас үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор тус газраас олон нийтэд архидалт, түүний хор уршгийг ойлгуулан таниулж соён гэгээрүүлэх ўйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллалаа. **Үүнд:**

Тус газраас ажлын байранд архидан согтуурахгүй байх, аливаа баяр ёслолыг архигүй тэмдэглэх, архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулж ажиллах чиглэлийг харьяа соёлын байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.

Мөн сар шинийн баярыг тохиолдуулан архи согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас, сошиал сувгаар таниулан сурталчилсан. [Архи, согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай - Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар \(mos.gov.mn\)](#) Ингэснээр баярыг архидалт болгон хавтгайруулан тэмдэглэхээс сэргийлэх юм.



-Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвүүд сар шинийн баярыг тохиолдуулан сумын Цагдаагийн хэсэгтэйгээ хамтран ойр орчны аюулгүй байдлыг ханган ажиллах хуваарийн дагуу 1 удаа эргүүлд гарч ажилласан.

- Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагууд “Цагаан сар”-ын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажиллан архидан согтуурах, бэртэж гэмтэх аюулаас үрүдчилан сэргийлж, хараа хяналт тавин ажилласан.

-Аймгийн Төв номын сантай хамтран сар шинийн баярын өдрийг угтан “Архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нь” сэдвээр 35 боть номоор үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Б.Долгормаа
Б.ДОЛГОРМОАА